



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН  
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2016 оны 03 сарын 07 өдөр

Дугаар А/СЗ

Улаанбаатар хот


Журам батлах тухай

МУИС-ийн Дүрмийн 4.5.8.3 дахь заалт, МУИС-ийн Хөтөлбөрийн ерөнхий хорооны 2016 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ нь:

1. "Хавсарга хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх журам"-ыг хавсралтаар баталсугай.


2. Журмыг хэрэгжүүлэн зохион байгуулах, үр дүнд нь хяналт тавьж ажиллахыг Сургалтын нэгдсэн алба (Ч.Ундрам), Мэдээллийн технологийн алба (А.Баатарбилэг), бүрэлдэхүүн сургуулийн захирал, сургалтын албаны эрхлэгч нарт үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



Р.БАТ-ЭРДЭНЭ

Захирлын 2016 оны 03 дугаар сарын 07-ны  
өдрийн 153 дугаар тушаалын хавсралт



## ХАВСАРГА ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

### НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. МУИС-ийн оюутанд өргөн сонголтыг бий болгох зорилтын хүрээнд хавсарга хөтөлбөртэй холбоотой үүсэх харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино. Журмаар зохицуулагдахгүй асуудал гарвал МУИС-ийн Хөтөлбөрийн ерөнхий хороо шийдвэрлэнэ.

1.2. Хавсарга хөтөлбөрийг боловсруулах, батлах, өөрчлөх болон хэрэгжүүлэхэд МУИС-ийн Хөтөлбөрийн хорооны /түр/ журам, Сургалтын журам болон энэхүү журмыг баримтална.

1.3. Хавсарга хөтөлбөр гэдэг нь тодорхой болзол хангасан оюутанд суралцаж байгаа үндсэн мэргэжлийнхээ зэрэгцээ өөр мэргэжлийн чиглэлээр системтэй мэдлэг, чадвар эзэмшүүлэх зорилготой боловсролын зэрэг олгохгүй хөтөлбөр юм.

### ХОЁР. ХАВСАРГА ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХ

2.1. Хавсарга хөтөлбөрийг МУИС-ийн Хөтөлбөрийн ерөнхий хороогоор батлуулан хэрэгжүүлж байгаа бакалаврын үндсэн хөтөлбөрийн чиглэлээр (нэрээр) боловсруулна.

2.2. Хавсарга хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөө нь үндсэн хөтөлбөрийн “мэргэжлийн суурь” болон “мэргэжлийн” хичээлүүдээс бүрдэх бөгөөд 30 багц цагаас багагүй /Сургалтын журам 3.6.11/ багтаамжтай байна.

2.3. Хавсарга хөтөлбөр нь тухайн хөтөлбөрийн зорилго, агуулга, сургалтын орчин, суралцагчдад тавигдах тусгай шаардлагаас бүрдэнэ (маягт 1). Үүнд:

2.3.1. Хөтөлбөрийн зорилго: тухайн хавсарга хөтөлбөрөөр суралцагчид эзэмшүүлэх системтэй мэдлэг, ур чадвар;

2.3.2. Хөтөлбөрийн агуулга: сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр;

2.3.3. Сургалтын орчин: багш, анги танхим, лабораторийн хүрэлцээ;

2.3.4. Тусгай шаардлага: хавсарга хөтөлбөрийн онцлогоос хамаарч тэнхим шаардлага тавьж болно /суурь мэдлэг, ур чадварын шалгалт авах гэх мэт/.

### ГУРАВ. ХАВСАРГА ХӨТӨЛБӨРӨӨР СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ

3.1. Хавсарга хөтөлбөрийг, тухайн хөтөлбөрийг боловсруулсан мэргэжлийн тэнхим сургалтын албатай хамтран хэрэгжүүлнэ.



3.2. Оюутан үндсэн мэргэжлийн зэрэгцээ хоёр хүртэл хавсарга хөтөлбөрт зэрэг суралцаж болох бөгөөд хөтөлбөр бүрд тавигдах шаардлагыг хангана /Сургалтын журам 3.6.11, 4.5.9, энэ журмын 2.3.4/.

3.3. МУИС-ийн ерөнхий суурь болон үндсэн мэргэжлийн суурь хичээлийг бүрэн, мэргэжлийн хичээлийн багц цагийн 1/3-ийг амжилттай судалсан МУИС-д суралцаж буй 2,6-аас багагүй голч дүнтэй оюутан хавсарга хөтөлбөрөөр суралцах хүсэлтээ (маягт 2) 3 болон 10 дугаар сард гаргана.

3.4. Сургалтын төлөвлөгөөний дагуу өмнө нь амжилттай судалсан, хавсарга хөтөлбөрт байгаа хичээлийг дүйцүүлэн тооцно. Үндсэн мэргэжлийн сургалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй хавсарга хөтөлбөрийн хичээлийн дүнг голч дүнд тооцохгүй.

3.5. Хавсарга хөтөлбөрөөр суралцагч хичээлээ үндсэн мэргэжлийн хөтөлбөрөөр суралцагчидтай хамт судлах бөгөөд нэг улиралд судлах багц цаг 21-ээс илүүгүй байх сургалтын журмын 4.5.9 заалтыг мөрдөнө.

3.6. Хавсарга хөтөлбөрөөр суралцах явцдаа оюутан тухайн чиглэлээрээ үргэлжлүүлэн хос мэргэжлээр суралцах хүсэлт гаргаж болно.

3.7. Хавсарга хөтөлбөрийн эрэлт, хэрэгцээ /суралцах хүсэлт гаргасан оюутны тоо/ сургалт явуулах бодит боломжоос хэтэрсэн тохиолдолд оюутны голч дүнг үндсэн шалгуур болгон зохицуулалт хийнэ.

3.8. Хөтөлбөрөө амжилттай дүүргэсэн оюутанд “Хавсарга хөтөлбөрийн гэрчилгээ” олгоно. Гэрчилгээнд хавсарга хөтөлбөрийн нэр, амжилттай судалсан хичээлийн нэрс, тэдгээрийн багц цаг, дүн байх бөгөөд голч дүнг тусгайлан бодохгүй. Гэрчилгээний загварыг Сургалтын нэгдсэн албанаас батална.

3.9. Үндсэн мэргэжлээрээ төгсөх хугацаандаа хавсарга хөтөлбөрөө дуусгаагүй оюутны хүсэлтийг харгалзан амжилттай судалсан хичээлүүдийг үндсэн мэргэжлийн чөлөөт сонголтын хичээлд тооцох, эсвэл үндсэн мэргэжлээрээ төгссөнөөсөө хойш 1.5 жилийн дотор хавсарга хөтөлбөрөө гүйцээн судалж, гэрчилгээ авч болно.

#### ДӨРӨВ. БУСАД

4.1. Хавсарга хөтөлбөрийн суурь үйлчилгээний болон багц цагийн төлбөр нь тухайн хичээлийн жилийн сургалтын төлбөрийг тогтоосон хувь хэмжээгээр тодорхойлогдох бөгөөд оюутан сургалтын журмын 4.13.6-д заасны дагуу төлнө.

4.2. Үндсэн мэргэжлээрээ төгссөн боловч хавсарга хөтөлбөрт суралцаж байгаа оюутан тухайн хавсарга хөтөлбөрийг хэрэгжүүлж буй бүрэлдэхүүн сургуулийн харъяалалд шилжиж харгалзах суурь үйлчилгээний болон багц цагийн төлбөрийг төлнө.

4.3. Оюутан “Хавсарга хөтөлбөрийн гэрчилгээ” авахдаа сургалтын журмын 4.12.4.13-т заасны дагуу хураамж төлнө.

4.4. Тэнхим, сургалтын алба хавсарга хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр ашгийг тооцон, мониторинг хийж, тэнхмийн болон бүрэлдэхүүн сургуулийн тайланд тусгана.

**ХАВСАРГА ХӨТӨЛБӨРИЙН ҮЛГЭРЧИЛСЭН МАЯГТ**



**I. Ерөнхий мэдээлэл**

Хавсарга хөтөлбөрийн нэр: ..... (Тусгай зөвшөөрөл дэх албан ёсны нэр)

Уялдах үндсэн хөтөлбөр, индекс: .....

Хөтөлбөрийн зорилго: (тухайн хавсарга хөтөлбөрөөр суралцагчид эзэмшүүлэх системтэй мэдлэг, ур чадвар) .....

.....

Хөтөлбөрийн харьяалал: (тухайн хөтөлбөрийг хариуцах бүрэлдэхүүн сургууль, тэнхимийн нэр)

.....

**II. Холбогдох/нэмэлт мэдээлэл**

Суралцах орчин: (багш, анги танхим, лабораторийн хүрэлцээ)

**Багшийн мэдээлэл**

	Эрдмийн зэрэг	Нийт
Үндсэн багшийн тоо		
Цагийн болон туслах багшийн тоо		
Нийт		

**Үндсэн хөтөлбөрт үйлчилдэг анги танхим, лабораторийн мэдээлэл**


	Ангийн тоо	Суудлын тоо
Анги/танхим		
Лаборатори/кабинет		
Нийт		

**Үндсэн хөтөлбөрт хамрагдаж буй оюутны тоо**

	1	2	3	4	Нийт
Түвшин					

**II. Хөтөлбөрийн агуулга: (сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр)**

Захирлын ..... тоот тушаалаар батлагдсан ..... хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсэг



Хянасан: ..... Сургалтын нэгдсэн албаны дарга

**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ**  
..... СУРГУУЛИЙН ..... САЛБАР

**СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**  
(Хавсарга мэргэжлийн)

Хавсарга мэргэжил:  
Нийт багц цаг: 30 ≤

Д/д	Хичээлийн индекс	Хичээлийн нэр	Багц цаг	Улирал
<b>А. ЗААВАЛ СУДЛАХ ХИЧЭЭЛ</b>				
				I, II
				I, II
				I, II
				I, II
				I, II
<b>Б. СОНГОН СУДЛАХ ХИЧЭЭЛ</b>				
				I, II
				I, II
				I, II
				I, II
				I, II
<b>НИЙТ БАГЦ ЦАГ</b>				30 ≤

Суралцагчид тавигдах тусгай шаардлага:

.....

.....-ын тэнхмийн хөтөлбөрийн дэд хорооны дарга  
..... /...../

.....-ын сургуулийн Сургалтын албаны эрхлэгч  
..... /...../





**ХАВСАРГА ХӨТӨЛБӨРӨӨР СУРАЛЦАХ ХҮСЭЛТИЙН МАЯГТ**

1	Оюутны овог, нэр	
2	Оюутны дугаар	
3	Регистрийн дугаар	Хүйс.....
4	Бүрэлдэхүүн сургууль	
5	Суралцаж байгаа хөтөлбөр	
6	Түвшин	
7	Голч дүн	
8	Хүсэлт	МУИС-ийн ..... бүрэлдэхүүн сургуулийн ..... хавсарга хөтөлбөрөөр суралцах хүсэлтэй байна.
9	Хүсэлт гаргасан оюутны гарын үсэг	
10	Холбоо барих утасны дугаар, цахим шуудангийн хаяг	
11	Хүсэлт гаргасан огноо	
12	Хүлээж авсан сургалтын албаны мэргэжилтэний гарын үсэг	
13	Хүлээж авсан огноо	

*Оюутан та энэхүү хүсэлтийг гаргахаас өмнө МУИС-ийн Сургалтын эсурал, Хавсарга хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх эсурмуудыг анхааралтай уншиж танилцана уу.*

Хүсэлтийн хариу тайлбар, шийдвэр:

Тэнхим:                                      Зөвшөөрсөн                                      Татгалзсан  
\_\_\_\_\_ /Тэнхмийн эрхлэгч/

Тайлбар (бүрэлдэхүүн сургуулийн захирлын тушаал гарсан эсэх)

.....  
.....

\_\_\_\_\_ /Сургалтын албаны эрхлэгч/

20.... оны ..... сарын ..... өдөр